

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Арвайхээр хот
2026 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудитор О.Батжаргал
Утас: 70323253, цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер П.Хорлоосүрэн Утас:70323108
цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Р.Мягмарсүрэн Утас: 70323108
цахим хаяг: Myagmarsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/24

Арвайхээр сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2026 оны А/32 дугаар тушаалаар баталсан аудитын төлөвлөгөө, 2025 оны А/175 дугаар тушаалаар баталсан "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Өвөрхангай аймгийн Сонгуулийн хорооны дарга (Ц.Ганболд)-д хүргүүлсүгэй.

3. Сонгуулийн зардлын тайланг байгууллагын сайт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэхийг аудитор (Р.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг аудитор (Р.Мягмарсүрэн)-д даалгасугай.



О.БАТЖАРГАЛ

6225010057

Агуулга:

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүй	4
БҮЛЭГ 1. Орон нутгийн 2026 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна	5
1.1 Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна	5
1.2 Сонгуулийн зардлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зарцуулсан байна	6
БҮЛЭГ 2. Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, 1.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна	7
2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 1.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	7
2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой, үнэн зөв тайлагнасан байна.	9
ДҮГНЭЛТ 9	

Хүснэгтийн жагсаалт:

Хүснэгт 1 Сумдын сонгуульд ажилсан албан хаагчдын мэдээлэл	6
Хүснэгт 2 Аймгийн сонгуулийн хорооны хуваарилсан санхүүжилт	6
Хүснэгт 3 Сонгуулийн хорооны нийт зардлын гүйцэтгэл	8
Хүснэгт 4 Цалин түүнтэй адилтгах орлогоос суутгасан НДШ, ХАОАТ	9

Зурган жагсаалт:

График 1	8
----------------	---

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ӨВА	Өвөрхангай аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ХХОАТХ	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
МТБ	Мэдээлэл технологийн баг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Аудит
хийх
үндэслэл,
бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүй

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8¹, 10.11², Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.5-д заасны дагуу Орон нутгийн 2025 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Өвөрхангай аймгийн Сонгуулийн хорооны зардлын тайланд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3³-т заасныг баримтлан нийцлийн аудит хийлээ.

Аудитын
зорилт

Нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:Орон нутгийн нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх

Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнасан эсэх

Аудитын
хамарсан
хүрээ

Аудитыг Орон нутгийн 2026 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан СЕХ-ноос аймгийн Сонгуулийн хороонд /аймаг, сумын 7 сонгуулийн хороо/ хуваарилан зарцуулсан төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын баримт материалуудыг хамруулан хэрэгжүүллээ.

¹ Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана.

² Аймаг, нийслэлийн Хурлын сонгуулийн хороодын тайланд тухайн орон нутаг дахь төрийн аудитын салбар байгууллагаар дүгнэлт гаргуулна.

³ Төрийн аудитын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1.шалгагдагч этгээдэд энэ хуулийн 11, 12 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

6.3.2.Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/-аас Монгол Улсын Их Хурал /цаашид "Улсын Их Хурал" гэх/-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх;

6.3.3.төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх;

6.3.4.нийтийн өмчтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актыг боловсронгуй болгох, батлан гаргах талаар эрх бүхий этгээдэд зөвлөмж өгөх.

Шалгуур
үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-1:2020 "Төрийн аудит, Тулгуур зарчим", MNS6817-6:2020 "Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим", MNS6817-8:2020 "Төрийн аудит. Нийцлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалын дагуу шалгагдагч болон хамрагдагч байгууллагын сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Сонгуулийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер П.Хорлоосүрэн хэрэгжүүлж, аудитор Р.Мягмарсүрэн нар гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сонгуулийн Ерөнхий хорооноос Өвөрхангай аймагт 2026 оны орон нутгийн нөхөн сонгуулийн зардалд нийт 317.8 сая төгрөгийн төсөв олгосон байна. Мөн аймгийн сонгуулийн хорооны 2026 оны 09, 10 дугаар тогтоолуудаар төсвийг хуваарилжээ. Үүнээс аймгийн Сонгуулийн хороо 56.1 сая төгрөг, Сумдын Сонгуулийн хороо 260.4 сая төгрөгийг тус тус зарцуулж, 1.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн, харин бусад эх үүсвэрээс хөрөнгө зарцуулаагүй байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ 2026 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

БҮЛЭГ 1. Аймаг, сумдын 2026 оны нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1 Сонгуулийн хороодод төсвийг журмын дагуу хуваарилсан байна.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хороог аймгийн ИТХ-ын 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 14/01 тоот тогтоолоор 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Мөн аймгийн Сонгуулийн хорооны даргын захирамжаар нягтлан бодогч 1, бичиг хэргийн ажилтан 1-ийг томилсноор нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна. Аймгийн хэмжээнд аймаг, сумын 7 сонгуулийн хороонд нийт 269 төрийн албан хаагч, үүнээс аймгийн сонгуулийн хороонд 9,

сумын сонгуулийн хороонд 39, хэсгийн хороонд 192, мэдээлэл технологийн багт 29 албан хаагч ажилласан байна.

Хүснэгт 1 Сумдын сонгуульд ажилсан албан хаагчдын мэдээлэл

№	Сумдын нэр	Мандатын тоо	Хэсгийн тоо	Сонгуулийн хороонд ажилласан албан хаагч	Хэсгийн хороонд ажилласан албан хаагч	Мэдээлэл технологийн ажилтан
1	Баянгол	1	1	7	9	1
2	Есөнзүйл	1	4	5	40	5
3	Зүүнбаян-Улаан	1	1	5	9	2
4	Нарийн тээл	1	1	5	9	2
5	Төгрөг	1	5	5	62	6
6	Хайрхандулаан	1	6	5	52	7
7	Арвайхээр	1	1	7	11	2
8	Өвөрхангай сонгуулийн хороо			9		4
Дүн		7	19	48	192	29
Нийт албан хаагчийн тоо				269		

/Эх сурвалж: Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

Аймгийн хэмжээнд 19 хэсэгт сонгуулийн насны 9601 иргэнийг сонгогчийн нэрсийн жагсаалтад бүртгэсэн байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны шийдвэрээр Өвөрхангай аймгийн Сонгуулийн хороонд нийт 317.8 сая төгрөгийн санхүүжилт хуваарилахаар баталсан байна. Уг санхүүжилтийг сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах төсөвт гурван үе шаттайгаар хуваарилж, зарцуулалтыг тайлбарын хамт албан бичгээр хүргүүлсэн байна.

Сонгуулийн төсвийн төслийг анхан шатны байгууллагаас гаргуулаагүй боловч Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу аймаг, сумын хүн амын тоо болон газар нутгийн хэмжээ зэрэг харьцуулсан үзүүлэлтэд үндэслэн төлөвлөсөн байна.

1.2 Сонгуулийн зардлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зарцуулсан байна.

Улсын төсвөөс олгох санхүүжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сум, хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол, унааны зардал, мэдээ дамжуулах зардал, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоонд үндэслэн бодитой тооцжээ.

Сонгуулийн ерөнхий хороо нь Өвөрхангай аймгийн Сонгуулийн хороонд нийт 317.8 сая төгрөгийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгосон байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь СЕХ-оос хүргүүлсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумдын Сонгуулийн хороонд нийт 260.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 2 Аймгийн сонгуулийн хорооны хуваарилсан санхүүжилт (төгрөгөөр)

№	СУМДЫН НЭР	ХУВААРИЛСАН САНХҮҮЖИЛТ
1	Баянгол	18,684,090.00
2	Есөнзүйл	49,565,130.00
3	Зүүнбаян-Улаан	17,467,998.00
4	Нарийн тээл	17,755,290.00
5	Төгрөг	64,718,110.00
6	Хайрхандулаан	63,963,050.00
7	Арвайхээр	21,112,250.00
8	Өвөрхангай сонгуулийн хороо	64,549,832.00
НИЙТ ДҮН		317,815,750.00

/Эх сурвалж: Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

Нөхөн сонгуулийн үйл ажиллагаанд олгосон санхүүжилтийн гүйлгээг бүртгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн шаардлагын дагуу анхан шатны баримтыг бүрдүүлсэн байна.

Сонгуулийн хороонд томилогдон ажилласан нийт төрийн албан хаагчдад олгох мөнгөн урамшуулал, хоолны зардлаас ХХОАТТХ-ийн дагуу (10%) албан татвар, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу (нийт-23.3%) шимтгэл ногдуулсан байна.

БҮЛЭГ 2. Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, 1.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна

2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 1.3 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн Ерөнхий хорооноос Өвөрхангай аймгийн Сонгуулийн хороонд нийт 317.8 сая төгрөгийг дараах зориулалтаар зарцуулахаар хуваарилсан байна. Үүнд:

- ✓ Маягт, үнэмлэх хэвлэх зардал
- ✓ Хариуцлагатай сонгогч сургалтын зардал
 - а/ Бичиг хэрэг
 - б/ Сургалтын цай, хоолны зардал
- ✓ Бичиг хэргийн зардал
- ✓ Шуудан холбооны зардал
- ✓ Унааны зардал
- ✓ Санал авах байр бэлтгэх зардал
- ✓ Сурталчилгааны зардал
- ✓ Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг Сонгуулийн ерөнхий хорооноос авах, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-нд буцаан хүлээлгэж өгөх зардал
 - а/ Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж, дагалдах хэрэгслийг СЕХ-оос авах унаа, томилолтын зардал
 - б/ Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг сумын сонгуулийн хороо, хэсгийн хороонд хүргэх
 - в/ Санал тоолох төхөөрөмж, дагалдах хэрэгслийг аймгийн Мэдээллийн технологийн баг СЕХ-ны Мэдээллийн технологийн төвд хүлээлгэн өгөх зардал
 - г/ Хэсгийн хорооны даамал санал тоолох төхөөрөмжийг аймгийн Мэдээллийн технологийн багт хүлээлгэн өгөх зардал
- ✓ Мэдээллийн технологийн багийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал
 - а/ МТБ-ийн гишүүн мэдээ дамжуулах холбооны зардал
 - б/ Унааны зардал
- ✓ Сонгуулийн автоматжуулсан систем ашиглах зардал
- ✓ Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал
- ✓ Томилолтын зардал
 - а/ Аймгийн сонгуулийн хороо сонгуулийн дүн, мэдээ болон холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардал
 - б/ Сумын сонгуулийн хорооноос аймгийн сонгуулийн хороонд сонгуулийн дүн, баримт бичиг хүлээлгэн өгөх томилолтын зардал
- ✓ Шуурхай багийн зардал

Аймаг, сумын Сонгуулийн хороо нь үйл ажиллагааны зардлыг СЕХ-ны баталсан зориулалтын дагуу 316.5 сая төгрөг зарцуулж, 1.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Нийт зардлын 231.8 сая төгрөг буюу 72.9 хувь нь сонгуулийн хорооны гишүүд болон мэдээлэл технологийн даамлуудын урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл эзэлж байна.

График 1



Сонгуулийн төсвийн зардлын гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 3 Сонгуулийн хорооны нийт зардлын гүйцэтгэл

(төгрөгөөр)

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	473,000.00	410,000.00	87%
2	Сургалтын зардал	1,275,000.00	1,274,300.00	100%
3	Бичиг хэргийн зардал	4,100,000.00	3,700,000.00	90%
4	Шуудан, холбооны зардал	5,100,000.00	5,100,000.00	100%
5	Унааны зардал	16,800,000.00	16,800,000.00	100%
6	Санал авах байр бэлтгэх зардал	5,700,000.00	5,700,000.00	100%
7	Сурталчилгаа	14,000,000.00	13,226,450.00	94%
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах зардал	23,780,000.00	23,779,997.00	100%
9	МТБ-ийн холбоо, унааны зардал	960,000.00	960,000.00	100%
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	1,260,000.00	1,260,000.00	100%
11	Томилолтын зардал	6,108,000.00	6,108,000.00	100%
12	Шуурхай багийн зардал	3,440,000.00	3,440,000.00	100%
13	С/Хорооны гишүүдийн урамшуулал НДШ	202,232,250.00	202,136,320.00	100%
14	МТБ-ын гишүүдийн урамшуулал НДШ	29,587,500.00	29,587,500.00	100%
15	Болзошгүй зардал	3,000,000.00	3,000,000.00	100%
16	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,333,183.00	
НИЙТ ДҮН		317,815,750.00	317,815,750.00	

/Эх сурвалж: Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой, үнэн зөв тайлагнасан байна.

Аймаг, сумын Сонгуулийн хороо нь СЕХ-оос хуваарилсан төсвийг СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын хавсралт 2, 3-н дагуу тайлагнасан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг шалгаж, санхүүгийн анхан шатны баримтуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлсэн, зардлын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт тавьж, хүлээн авсан байна.

Сонгуулийн зардлын дансны хуулгыг анхан шатны баримттай тулган шалгахад зарлагын гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу зарцуулж, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулан, тайлагнасан байна.

Сонгуулийн хорооны гишүүд болон мэдээлэл технологийн багийн гишүүдийн урамшуулал, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 231.8 сая төгрөг хуваарилан зарцуулсан байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлд /ажил олгогч/ - 25.6 сая төгрөг
- Нийгмийн даатгалын шимтгэлд /даатгуулагч/ - 23.3 сая төгрөг
- Хувь хүний орлогын албан татварын зардалд – 18.3 сая төгрөг
- Гарт олгосон урамшуулалд – 164.5 сая төгрөг тус тус зарцуулагджээ.

Хүснэгт 4

Цалин түүнтэй адилтгах орлогоос суутгасан НДШ, ХАОАТ

(төгрөгөөр)

Сумдын нэр	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	НДШ (ажил олгогч)	НДШ (даатгуулагч)	ХАОАТ
Баянгол	13,646,000.00	1,705,750.00	1,541,998.00	1,210,400.20
Есөнзүйл	37,654,000.00	4,706,750.00	4,254,902.00	3,339,909.80
Зүүнбаян-Улаан	12,678,000.00	1,584,750.00	1,432,614.00	1,124,538.60
Нарийн тээл	12,678,000.00	1,488,820.00	1,432,614.00	1,124,538.60
Төгрөг	50,142,000.00	6,267,750.00	5,666,046.00	4,447,595.40
Хайрхандулаан	48,358,000.00	6,044,750.00	5,464,454.00	4,289,354.60
Арвайхээр	16,322,000.00	2,040,250.00	1,844,386.00	1,447,761.40
Өвөрхангай сонгуулийн хороо	14,584,000.00	1,823,000.00	1,647,992.00	1,293,600.80
Төвлөрүүлэх шилжүүлэг		95,930.00		
Нийт дүн	206,062,000.00	25,757,750.00	23,285,006.00	18,277,699.40

/Эх сурвалж: Аймаг, сумын сонгуулийн хорооны санхүүгийн баримт/

Дүгнэлт

- Аймаг, сумдын 2026 оны нөхөн сонгуулийн зардлыг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн нөхөн сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, 1.3 сая төгрөг төвлөрүүлсэн байна.
- Зардлын гүйцэтгэлийг журамд заасны дагуу тайлагнасан байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас: www.audit.mn